

ТАНИЛЦУУЛГА

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.5-д “Хөдөлмөрийн хувийн биржийг бүртгэж, санхүүжилт олгох журмыг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална” гэж заасан. Мөн хуулийн 29 дүгээр зүйлийн 29.11-д хөдөлмөрийн хувийн биржийн үйл ажиллагааг тодорхойлсон.

Журамд заасан шаардлагыг ханган бүртгүүлсэн 62 хөдөлмөрийн хувийн биржид нийт 400 гаруй ажилтан ажиллаж байна. Ажилтныг ажлын чиг үүргээр задлан ажилд зуучлах үйлчилгээний мэргэжилтэн 164, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох зөвлөх 164, судалгааны ажилтан 80 байна.

2024 оны 8 дугаар сарын байдлаар 28 бирж тогтвортой үйл ажиллагаа явуулж байна. Байршлаар нь авч үзвэл нийт хөдөлмөрийн хувийн биржийн 80.0 гаруй хувь нь Улаанбаатар хотод, үлдсэн 20 хувь нь орон нутагт үйл ажиллагаа явуулж байна.

Завхан аймагт 1, Дорнод аймагт 4, Өмнөговь аймагт 1, Дундговь аймагт 1, Дархан-уул аймагт 1, Хөвсгөл аймагт 1, Увс аймагт 2 хөдөлмөрийн хувийн бирж тус тус үйл ажиллагаа явуулдаг.

Хөдөлмөрийн хувийн биржийн үйл ажиллагаа явуулах хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр Хөдөлмөрийн сайдын 2014 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн А/123 тушаалын хавсралтаар батлагдсан “Хөдөлмөрийн хувийн биржийг бүртгэж, санхүүжилт /тарифаар тооцож/ олгох журам” болон журмын хавсралт “Хөдөлмөрийн хувийн биржид санхүүжилт олгох тариф”-ыг шинэчлэх ажлыг гүйцэтгэж байна.

Журам болон тарифын шинэчлэлтэй холбоотой онцлох өөрчлөлтийг дурдвал дараах байдалтай байна. Үүнд:

- Хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь сонгон шалгаруулалтаар гэрээний үндсэн дээр хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ үзүүлэгч хөдөлмөрийн хувийн биржүүдийг нэгтгэсэн мэргэжлийн холбоонд хөдөлмөрийн хувийн биржийн бүртгэл, тайлагналт, хяналт хийх эрх, үүргээ шилжүүлэн гүйцэтгүүлж болно;
- Бүртгэлийн гэрчилгээний хугацаа 2 жил байсан бол 3 жил болгон өөрчилсөн. Мөн бүртгэлийн гэрчилгээний сунгалтын хугацаа нь анх олгосон хугацаатай адил байхаар тусгасан;
- Хөдөлмөрийн хувийн биржийн үйл ажиллагааны төрөл нэмэгдсэн ба ажил мэргэжил, хүн амын бүлэг, эдийн засгийн үйл ажиллагааны салбараар төрөлжсөн үйл ажиллагаа явуулж болох, мөн биржүүд нэгдэж нэгдсэн нэг цэгийн үйлчилгээ үзүүлэх болон салбар нэгжээр үйл ажиллагаа явуулна;
- Оролцогч талуудын эрх үүргийг тодорхойлсон ба хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага болон тус байгууллагаас эрх шилжүүлсэн байгууллагын хэрэгжүүлэх үйл ажиллагааг ангилсан;
- Хөдөлмөрийн хувийн биржийг бүртгэх эрх бүхий байгууллагын үйл ажиллагаанд хөндлөнгийн байгууллагаар жил бүр аудит хийлгэх тухай хяналтын зохицуулалтыг нэмсэн;
- Хөдөлмөрийн хувийн биржийн үйл ажиллагааны төрөл нэмэгдэж буйтай холбоотойгоор нэмэлт үйлчилгээнүүдийг тарифжуулж өгсөн. Мөн хэрэгжилт

хангалтгүй буюу санхүүжилт хийгддэггүй байсан зарим үйлчилгээг тарифын жагсаалтаас хассан;

- Тарифын хэмжээг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй жишсэн хувиар тооцож олгох өөрчлөлтийг хийсэн;
- Зорилтот бүлгээс хамаарч үйлчилгээнд зарцуулах цаг хугацаа харилцан адилгүй байдаг тул ажилд зуучлах үйлчилгээ, ажил мэргэжлийн ганцаарчилсан зөвлөгөө өгөх үйлчилгээний тарифыг ялгаатай байхаар тогтоосон.
- Хөдөлмөр эрхлэх чадварын үнэлгээ хийх, хөдөлмөр эрхлэх хувийн төлөвлөгөө боловсруулах үйлчилгээнүүд нэмэгдсэн.

Энэхүү журам батлагдсанаар хөдөлмөр эрхлэлтийн салбарын төр болон хувийн хэвшлийн хамтын ажиллагааг өргөжин хөгжиж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих нийтлэг үйлчилгээний хүртээмж нэмэгдэж, чанар сайжрах нөхцөл, боломж бүрдэх юм.

Жич: Зардал гэдэг нь бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулагдаж байгаа хөрөнгө болон хөдөлмөрийн зарцуулалт буюу найдвартай орлого олохын тулд өнөөдөр золиосолж байгаа хөрөнгийн бууралт юм. Зардлыг үйл ажиллагааны тодорхой объектод хамаатуулан тодорхой хугацаагаар зааглан хуримтлуулсныг өртөг

-----oO-----